



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн тухай хуулийн 13.5 “Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжилтэнд төгсгөлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Үнэлгээг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081211

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 17 өдрийн
345 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

“Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн төгсгөлийн үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд:

Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн

Н.Оюунгэрэл, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Н.Тунгалаг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Энхзаяа, Халдварт бус өвчний бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Д.Уранчимэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга


О.Батгэрэл, Бие бялдар сэргээн засах Монголын нийгэмлэгийн тэргүүн

Х.Ариунаа, Сэргээн засах тусламж үйлчилгээний мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Г.Туяа, Сэргээн засах тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

Ш.Батчимэг, АШУҮИС-ийн сэргээн засах тусламж үйлчилгээний багш /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 17 өдрийн
345 дугаар тушаалын 2 дүгээр
хавсралт



“Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн төгсгөлийн үнэлгээ хийх ажлын удирдамж

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

“Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 228 дугаар тушаалаар баталж, 2011-2015 онд хэрэгжүүлэхээр заасан байна.

“Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ 2013 онд хийгдэж, төгсгөлийн үнэлгээг энэ онд хийж, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, тулгамдсан асуудал, цаашдын хэрэгцээг тогтоох нь энэхүү ажлын үндэслэл болж байна.

2. Зорилго:

“Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд төгсгөлийн үнэлгээ хийж, цаашид сэргээн засах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах санал, зөвлөмж дэвшүүлнэ.


3. Үйл ажиллагааны чиглэл:

- “Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Стратегийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшинг тооцон шалтгаан, үр дүнд дүгнэлт хийнэ.
- Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг дүгнэнэ.
- Сэргээн засах тусламж үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, чанарын болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн боловсруулалт, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлнэ
- Ололт, амжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тусгасан дөвлөмж боловсруулна
- Стратегийг үргэлжлүүлэх эсэх талаар санал дэвшүүлнэ
- Нэмэлт шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна

Тухайн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэнд үнэлгээ өгнө.

4. Хамрах хүрээ:

- Удирдлага зохион байгуулалт
- Салбар хоорондын түншлэл
- Сэргээн засах мэргэжилтний хүний нөөцийн хөгжил
- Эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл
- Сэргээн засах тусламж үйлчилгээний техник, технологи
- Сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмж



Хамтран ажиллах тал:

- Эрүүл мэнд спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс
- ЭМСЯ-ны дэргэдэх Сэргээн засах тусламж үйлчилгээний мэргэжлийн салбар зөвлөл
- Хүн амын хөгжил нийгэм хамгааллын хөдөлмөрийн яамны харъяа Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв
- ДЭМБ
- ЭМСЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газар
- Нийслэлийн эрүүл мэндийн газар
- Герентологийн төв

5. Хугацаа: 2015 оны 08-10 дугаар сарын 1

Баримтын судалгааны болон ярилцлагын аргаар үнэлгээ хийнэ.


А. Баримтын судалгаанд дараах материалыг судлана.

- Хууль (эрүүл мэндийн тухай хууль, хөдөлмөрийн хууль, боловсролын тухай)
- Тушаал (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 444 тоот, 2012 оны 408 тоот, 2013 оны 27,61 тоот тушаалуудын хэрэгжилтэнд үнэлгээ өгнө)

Б. Ярилцлагын судалгаанд:

- ЭМСЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Р.Оюунханд
- Сэргээн засах үндэсний төвийн захирал Б.Нарантуяа
- Бие бялдар сэргээн засах Монголын нийгэмлэгийн тэргүүн О.Батгэрэл,
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сэргээн засах тусламж үйлчилгээний ахлах багш, дэд профессор А.Балжинням
- Улсын хоёрдугаар нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын менежер, сэргээн засах тасгийн эрхлэгч, эмч

- Рашаан судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Г.Туяа
- Сонгино хайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын менежер, сэргээн засах тасгийн эрхлэгч, эмч
- Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын менежер, сэргээн засах тасгийн эрхлэгч, эмч
- Орхон аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын менежер, сэргээн засах тасгийн эрхлэгч, эмч нартай биечлэн уулзаж ярилцана.



6. Хүрэх үр дүн: Стратегийн төгсгөлийн үнэлгээний дүнгийн тайлан, санал, зөвлөмж, гарч, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна.